

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ГАА-2025/139/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

АДЭБ. ДН. ДН № 136

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүйсийн говь-цэцэг нуурын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Ахмадын сангийн данс нээн 5,600.0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөл аваагүй,
- Төсвийн шууд захирагч тушаал шийдвэргүйгээр 653.3 мянган төгрөгийн урамшуулал авсан,

8225020395

- Төсвийн зарлагын хэмнэлт, давсан орлогыг хуваарилахдаа 60.0 хувиас хэтрүүлэн ажиллагсдад 1,306.7 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон,
- Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардлын төсвөөс 828.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас хэрэгсэл худалдан авч, шууд зардлаар тайлагнаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Байгууллагын Ниссан патрол Y61 маркийн авто тээврийн хэрэгслийг гаднын байгууллагад гэрээ байгуулаагүйгээр /8,296км/ ашиглуулж, хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/885 дугаар тушаалаар тус байгууллагын давсан орлогоос 3,920.0 мянган төгрөгийг хуваарилсан, байгаль хамгаалах болон усны чиглэлийн судалгаа шинжилгээ хийх, сургалт зохион байгуулахаар Дэлхийн байгаль хамгаалах сангаас 38,313.3 мянган төгрөг, Усны газраас 8,054.0 мянган төгрөг, нийт 50,287.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон нь баталсан төсвийн 20.0 хувийг эзэлж байна.

Тайлант онд Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа нь Монгол Улсын хэмжээнд анх удаа Хөв цөөрөм байгуулах газрын судалгааны ажлыг зохион байгуулан тус ажлын хүрээнд 10 сумын 21 газар дээр хөв цөөрмийн байршлыг тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүй.

Тайлант онд 263,654.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 244,812.8 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байна.

Баталсан орон тоогоор бүрэн ажилласан боловч төсвийн хэмнэлтийн 80.0 хувь цалингийн зардлын хэмнэлт байгаа нь төлөвлөлтийг үндэслэлтэй хийгээгүйг харуулж байна.

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 10 зорилт, 55 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 87.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|----------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,830,500.0 | 8,561,850.0 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 5,600,000.0 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 5,600,000.0 |
| 31210 | Төгрөг | - | 5,600,000.0 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 5,600,000.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,830,500.0 | 2,961,850.0 |
| 35400 | Хангамжийн материал | 2,830,500.0 | 2,961,850.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 307,500.0 | 182,850.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 763,000.0 | 109,000.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,760,000.0 | 2,670,000.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН ЕУС ХӨРӨНГИЙН ДҮН | 353,521,812.3 | 319,709,540.3 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 353,521,812.3 | 319,709,540.3 |
| 39200 | Биет хөрөнгө | 353,521,812.3 | 318,441,606.9 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 321,726,996.5 | 321,726,996.5 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (22,737,000.1) | (60,242,937.1) |
| 39205 | Машин тоног тэхөөрөмж(компьютер) | 57,393,000.0 | 62,361,300.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (9,294,770.8) | (10,636,529.2) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,810,100.0 | 6,340,100.0 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,376,513.3) | (1,107,323.3) |
| 39300 | Биет бус хөрөнгө | - | 1,267,933.3 |
| 39301 | Программ хангамж | - | 1,267,933.3 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 356,352,312.3 | 328,271,390.3 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 356,301,398.5 | 328,271,390.3 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 356,301,398.5 | 328,271,390.3 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 356,301,398.5 | 328,271,390.3 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 44,047,763.7 | 356,301,398.5 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 312,253,634.8 | (28,030,008.3) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 356,352,312.3 | 328,271,390.3 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|--|----------------------|----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 564,423,116.5 | 330,878,163.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 269,647,496.5 | 16,936,233.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 269,647,496.5 | 16,936,233.3 |
| 120009 | Бусад орлого | - | 5,600,000.0 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 269,647,496.5 | 11,336,233.3 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 294,775,620.0 | 313,941,930.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 265,687,900.0 | 263,654,600.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 265,687,900.0 | 263,654,600.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 29,087,720.0 | 50,287,330.0 |

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

| | | | |
|-------------|--|----------------------|----------------------|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 23,287,720.0 | 38,313,330.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 800,000.0 | 11,974,000.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 252,169,481.7 | 358,908,171.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 252,169,481.7 | 358,908,171.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 207,773,133.5 | 321,254,124.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 119,716,204.1 | 171,107,922.0 |
| 210101 | Үндсэн цалин | 79,846,640.1 | 93,998,542.0 |
| 210102 | Нэмэгдэл | 26,607,364.0 | 51,434,480.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,704,000.0 | 14,250,000.0 |
| 210104 | Урамшуулал | 8,558,200.0 | 11,424,900.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,965,025.5 | 20,764,397.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,195,744.4 | 14,239,407.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,192,320.3 | 1,541,535.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 953,976.1 | 830,575.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 238,344.1 | 830,575.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,384,640.6 | 3,322,303.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,440,000.0 | 18,023,400.0 |
| 210304 | Байрны түрээс | 18,440,000.0 | 18,023,400.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,344,940.0 | 20,286,054.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 225,800.0 | 602,370.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,437,020.0 | 17,380,730.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 852,170.0 | 990,354.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,829,950.0 | 1,312,600.0 |
| 2105 | Норматив зардал | - | 1,482,000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,482,000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,555,000.0 | 2,200,000.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.0 | 2,200,000.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,956,200.0 | 30,850,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,956,200.0 | 30,850,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,189,016.0 | 5,641,844.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 4,420,000.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 759,000.0 | 710,000.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 215,016.0 | 174,844.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 61,000.0 | 97,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 154,000.0 | 240,000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,606,747.9 | 50,898,505.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 5,750,000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,606,747.9 | 45,148,505.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,396,348.2 | 37,654,047.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,079,800.0 | 18,812,300.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,892,300.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 3,920,000.0 |

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

| | | | |
|--------|---|---------------|----------------|
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 32,316,548.2 | 18,841,747.5 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,316,548.2 | 18,841,747.5 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 312,253,634.8 | (28,030,008.3) |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 312,253,634.8 | (28,030,008.3) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|--------|--|---------------|---------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 294,775,620.0 | 319,541,930.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 5,600,000.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 5,600,000.0 |
| 120009 | Бусад орлого | - | 5,600,000.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 294,775,620.0 | 313,941,930.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 265,687,900.0 | 263,654,600.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 265,687,900.0 | 263,654,600.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 29,087,720.0 | 50,287,330.0 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 23,287,720.0 | 38,313,330.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 800,000.0 | 11,974,000.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 244,753,520.0 | 313,941,930.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 244,753,520.0 | 313,941,930.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 200,357,171.8 | 276,287,882.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 119,665,290.3 | 171,158,835.8 |
| 210101 | Үндсэн цалин | 80,048,002.9 | 101,692,313.8 |
| 210102 | Нэмэгдэл | 26,221,001.4 | 43,087,311.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,989,000.0 | 15,128,095.0 |
| 210104 | Урамшуулал | 8,407,286.0 | 11,251,115.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,965,025.5 | 20,764,397.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,195,744.4 | 14,119,790.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,192,320.3 | 1,661,151.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 953,976.1 | 830,575.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 238,344.1 | 830,575.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,384,640.6 | 3,322,303.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,440,000.0 | 18,023,400.0 |
| 210304 | Байрны түрээс | 18,440,000.0 | 18,023,400.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,823,640.0 | 21,071,404.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 514,500.0 | 479,720.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,667,020.0 | 18,290,730.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 852,170.0 | 990,354.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,789,950.0 | 1,310,600.0 |
| 2105 | Норматив зардал | 763,000.0 | 828,000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 763,000.0 | 828,000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,555,000.0 | 2,200,000.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.0 | 2,200,000.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,956,200.0 | 30,850,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,956,200.0 | 30,850,000.0 |

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

| | | | |
|-------------|---|---------------------|---------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,189,016.0 | 5,641,844.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 4,420,000.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 759,000.0 | 710,000.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 215,016.0 | 172,844.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 61,000.0 | 99,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 154,000.0 | 240,000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.0 | 5,750,000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 5,750,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,396,348.2 | 37,654,047.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,079,800.0 | 18,812,300.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,892,300.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 3,920,000.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 32,316,548.2 | 18,841,747.5 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 32,316,548.2 | 18,841,747.5 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 50,022,100.0 | 5,600,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | - | 5,600,000.0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 5,600,000.0 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----------|---|-----------------------|--|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл | 44,047,763.70 | 44,047,763.70 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 44,047,763.70 | 44,047,763.70 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 312,253,634.82 | 312,253,634.82 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл | 356,301,398.52 | 356,301,398.52 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нэрэх үлдэгдэл | 356,301,398.52 | 356,301,398.52 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 356,301,398.52 | 356,301,398.52 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | (28,030,008.26) | (28,030,008.26) |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-нарх үлдэгдэл | 328,271,390.26 | 328,271,390.26 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|---|----------------------|----------------------|---------------------|--------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 263,654,600.0 | 244,812,852.5 | 18,841,747.5 | 92.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 263,654,600.0 | 244,812,852.5 | 18,841,747.5 | 92.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 248,762,300.0 | 229,920,552.5 | 18,841,747.5 | 92.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 186,670,200.0 | 171,158,835.8 | 15,511,364.2 | 91.7 |
| 210101 | Үндсэн цалин | 102,168,300.0 | 101,692,313.8 | 475,986.2 | 99.5 |
| 210102 | Нэмэгдэл | 46,103,400.0 | 43,087,311.9 | 3,016,088.2 | 93.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,927,200.0 | 15,128,095.0 | 9,799,105.0 | 60.7 |
| 210104 | Урамшуулал | 13,471,300.0 | 11,251,115.2 | 2,220,184.9 | 83.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,333,800.0 | 20,764,397.9 | 2,569,402.2 | 89.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,866,900.0 | 14,119,790.6 | 1,747,109.5 | 89.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,866,700.0 | 1,661,151.8 | 205,548.2 | 89.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 933,400.0 | 830,575.9 | 102,824.1 | 89.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 933,500.0 | 830,575.9 | 102,924.1 | 89.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,733,300.0 | 3,322,303.7 | 410,996.4 | 89.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,440,000.0 | 18,023,400.0 | 416,600.0 | 97.7 |
| 210304 | Байрны түрээс | 18,440,000.0 | 18,023,400.0 | 416,600.0 | 97.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,072,400.0 | 9,970,074.9 | 102,325.1 | 99.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 480,000.0 | 479,720.0 | 280.0 | 99.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,000,000.0 | 8,000,000.0 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,092,400.0 | 990,354.9 | 102,045.1 | 90.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.0 | 500,000.0 | - | 100.0 |
| 2105 | Норматив зардал | 840,000.0 | 828,000.0 | 12,000.0 | 98.6 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 840,000.0 | 828,000.0 | 12,000.0 | 98.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,000,000.0 | 4,954,000.0 | 46,000.0 | 99.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,000,000.0 | 4,954,000.0 | 46,000.0 | 99.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,332,500.0 | 1,221,844.0 | 110,656.0 | 91.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 759,000.0 | 710,000.0 | 49,000.0 | 93.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 234,500.0 | 172,844.0 | 61,656.0 | 73.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.0 | 99,000.0 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.0 | 240,000.0 | - | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,000,000.0 | 3,000,000.0 | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.0 | 3,000,000.0 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 14,892,300.0 | 14,892,300.0 | - | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 14,892,300.0 | 14,892,300.0 | - | 100.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 14,892,300.0 | 14,892,300.0 | - | 100.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 263,654,600.0 | 244,812,852.5 | 18,841,747.5 | 92.9 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 263,654,600.0 | 244,812,852.5 | 18,841,747.5 | 92.9 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 263,654,600.0 | 244,812,852.5 | 18,841,747.5 | 92.9 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 15.0 | 15.0 | - | 100.0 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 7.0 | 7.0 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.0 | 5.0 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 7.0 | 7.0 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| ЭЗА | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ |
|--------|--|---------------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 50,287,330.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 50,287,330.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 46,367,330.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,101,330.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,290,730.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 810,600.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,200,000.0 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 2,200,000.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,896,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,896,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,420,000.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,420,000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,750,000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,750,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,920,000.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,920,000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,920,000.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 50,287,330.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,287,330.0 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 38,313,330.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,974,000.0 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 2,200.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Авто тээврийн хэрэгсэлд худалдан авсан 2,200.0 мянган төгрөгийг дугуйг шууд зарлагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 13,988.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,988.0 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 7,081.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 1,306.7 мянган төгрөгийн 1 зөрчил арилгах албан шаардлага, 5,600.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 2 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох санал өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Төлбөрийн акт

1. Ахмадын сангийн данс нээн 5,600.0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөл аваагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоол "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" 1 дүгээр зүйлийн 1.3-т "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 828.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас хэрэгсэл худалдан авч, шууд зардалд тайлагнан, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3. Төсөв захирагч тушаал шийдвэргүйгээр 653.3 мянган төгрөгийн урамшууллыг авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

1. Байгууллагын Ниссан патрол Y61 маркийн авто тээврийн хэрэгслийг гаднын байгууллагад гэрээ байгуулаагүйгээр /8,296км/ ашиглуулж, хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн эзэмшлийн хөрөнгийг бусдад ашиглуулахдаа зохих төсөв захирагчийн зөвшөөрлийн дагуу гэрээ хэлэлцээр байгуулахгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

2. Төсвийн зарлагын хэмнэлт, давсан орлогыг хуваарилахдаа 60.0 хувиас хэтрүүлэн ажиллагсад 1,306.7 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон нь Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаал "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 5.2-т "Энэ журмын 5.1.2, 5.1.3-т заасан зориулалтаар зарцуулах хөрөнгийн нийт хэмжээ төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй байна.", Монгол Улсын байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 12 сарын 18-ны өдрийн А/885 дугаар тушаал "Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлого дахин хуваарилах тухай"-ын 2-т "хуваарилсан орлогыг Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан журмын дагуу зарцуулахыг харьяа төсвийн шууд захирагч нарт даалгасугай" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давсан орлогыг журмын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй дарга С.Жаргалзаяад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

4. Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй нягтлан бодогчид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 5,600.0 мянган төгрөгийг орлого, зардлаар хүлээн зөвшөөрч давхардуулан илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 14 дүгээр зүйлийн 14.1-т "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж байх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|------------|---------|--------------|-----|---------|-----|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа | Авто тээврийн хэрэгсэлд худалдан авсан 2,200.0 мянган төгрөгийг дугуйг шууд зарлагдсан. | 1 | 2,200.0 | - | - | 1 | 2,200.0 | 1 | 2,200.0 | - | - | - | - |
| | дүн | 1 | 2,200.0 | - | - | 1 | 2,200.0 | 1 | 2,200.0 | - | - | - | - |

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | | |
|---|--|--------------------------|-----------------|---------------|----------------|-----------------|----------------|----------|----------------|-----------------------------------|----------|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | |
| Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа | Ахмадын сангийн данс нээн 5,600.0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөл аваагүй. | 1 | 5,600.0 | 1 | 5,600.0 | - | - | - | - | - | - | |
| | Нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 828.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас хэрэгсэл худалдан авч, шууд зардалд тайлагнаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. | 1 | 828.0 | 1 | 828.0 | - | - | - | - | - | - | |
| | Төсөв захирагч тушаал шийдвэргүйгээр 653.3 мянган төгрөгийн урамшууллыг авсан байна. | 1 | 653.3 | 1 | 653.3 | - | - | - | - | - | - | |
| | Төсвийн зарлагын хэмнэлт, давсан орлогыг хуваарилахдаа 60 хувиас хэтрүүлэн ажиллагсад 1,306.7 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон байна. | 1 | 1,306.7 | - | - | 1 | 1,306.7 | - | - | - | - | |
| | Байгууллагын Ниссан патрол Y61 маркийн автотээврийн хэрэгслийг гаднын байгууллагад гэрээ байгуулаагүйгээр /8,296км/ ашиглуулж, хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна. ашиглуулсан. | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | - | |
| | Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 5,600.0 мянган төгрөгийг орлого, зардлаар хүлээн зөвшөөрч давхардуулан илүү тайлагнасан. | 1 | 5,600.0 | - | - | - | - | - | 1 | 5,600.0 | - | - |
| | Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүй. | 1 | - | - | - | - | - | - | - | - | 2 | - |
| дүн | | 7 | 13,988.0 | 3 | 7,081.3 | 2 | 1,306.7 | 1 | 5,600.0 | 2 | - | |

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-------------------------|-------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | | 1 | | |
| | НИЙТ | | 1 | | | | 1 | | |